



## **МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР**

[www.sportarbitration.mn](http://www.sportarbitration.mn)



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



# ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Арбитрч нарт зориулсан суурь мэдлэг олгох хөтөлбөр

Монголын Олон улсын ба үндэсний спортын Арбитрын допингийн Давж заалдах комиссын гишүүн Э.Золжаргал

2026.06.07



## Комиссын эрх зүйн статус ба хэргийн харьяалал

**Үндсэн статус:** Спортын арбитрын дэргэдэх допингийн Давж заалдах комисс нь допингийн маргааныг эцсийн шатны арбитраар дагнан шийдвэрлэх хараат бус, мэргэшсэн бүтэц юм.

**Давж заалдах харьяалал:** Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллага (МОНАДА) болон Спортын холбоодын дэргэдэх допингийн анхан шатны комиссоос гаргасан шийдвэрийг хянах цорын ганц эрх бүхий байгууллага мөн.

**Анхаарах зарчим:** Дэлхийн Допингийн Эсрэг Кодекс (WADA Code)-ын стандартыг Монгол Улсын хэмжээнд нэг мөр мөрдүүлэх, тамирчин болон спортын байгууллагын эрхийг хамгаалахад чиглэнэ.



## Бүрэлдэхүүнийг томилох, татгалзан гаргах журам

**Бүрэлдэхүүнийг сонгох:** Комиссын даргаас томилсон арбитрчдаас бүрдсэн 3 гишүүнтэй бүрэлдэхүүн хянан шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүнд Хууль, Ангаах ухаан, Спортын салбараас тус бүр нэг нэг төлөөлөлөөс бүрдсэн байна. Хууль зүйн салбарын төлөөлөл бүрэлдэхүүнийг даргална.

**Ашиг сонирхлын зөрчил ба Тангараг:** Бүрэлдэхүүн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос өмнө талуудаас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй байх, нууцлалын тухай тунхаглалд гарын үсэг зурна.

**Татгалзан гаргах:** Бүрэлдэхүүн нь хараат бус, шударга байж чадах эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ төрвөл талууд болон бүрэлдэхүүн хараат бус байдлын мэдүүлгийг хүлээн авсанаас хойш 7 хоногийн /ОУ-ын маргаанд 14 хоногийн /дотор комиссын ажлын алба эсхүл комиссын даргад холбогдох баримтын хамт татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй.



## **Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн горим**

**Хувийн нууц ба Хаалттай горим:** Допингийн маргааныг хянан шийдвэрлэх хуралдаан, хэргийн материал, явцын мэдээлэл нь чанд нууцын зэрэглэлтэй байна. Хуралдааныг хаалттай явуулах хүсэлт гаргасанаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.

**Ажиллагааны хэл:** Ажиллагааг Монгол хэлээр явуулна. Хэрэв гадаадын иргэн, тамирчин оролцож байгаа тохиолдолд талууд өөрсдийн зардлаар баталгаат орчуулагчаар хангана.

**Түр арга хэмжээ авах:** Хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл тамирчны тэмцээн уралдаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлэх эсвэл МОНАДА-гийн шийдвэрийн биелэлтийг түр зогсоох зэрэг яаралтай арга хэмжээг бүрэлдэхүүн бие даан шийдвэрлэх эрхтэй.

**Хуралдаан явуулах хэлбэр:** биечлэн, цахим, бүрэлдэхүүн бие даан явуулах



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



## Нотлох баримт гаргуулах, түүнийг цуглуулах

**Нотлох баримт гаргах:** Талууд Өргөдөлийн шаардлагаа нотлох, үгүйсгэх нотлох баримтаа өөрсдөө гаргаж өгөх үүрэгтэй.

**Талуудын хүсэлт:** талууд өөрсдөө олж авч чадахгүй баримтын талаар бүрэлдэхүүнд хүсэлт тавьж нөгөө талаас эсхүл 3 дагч этгээдээс гаргуулж авч болно.

**Бүрэлдэхүүн:** хэрэгийг хянан шийдвэрлэх явцад бүрэлдэхүүн шаардлагтай гэж үзвэл өөрийн санаачлагаар нотлох баримтыг бүрдүүлж болно.

**Нотлох баримт танилцуулах болон шаардлага:** нотдох баримтыг хэрэгт авагдсан даруйд нарийн бичгээс бүрэлдэхүүн болон оролцогч нарт мэдэгдэж танилцуулах ёстой. Хуурамч болон хууль бус аргаар нотлох баримт цуглуулахыг хориглоно.



## Хугацаа тоолох журам ба Хэргийн зардал

**Хугацаа тоолох:** Дүрмээр тогтоосон хугацааг тоолохдоо мэдэгдэл, шийдвэрийг хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс эхлэн тоолно. Хэрэв хугацааны эцсийн өдөр Бямба, Ням гараг болон нийтээр амрах баярын өдөр таарвал түүний дараагийн ажлын өдөр хугацаа дуусах хугацаанд тооцогдоно.

**Комиссын зардал:** Зардалд комиссын хураамж, шинжээчийн төлбөр, орчуулгын зардал, хуралдааны зохион байгуулалтын зардал багтана.

Зардлыг хуваарилахдаа хэргийн нөхцөл байдал, талуудын буруутай үйлдэл, маргааны үр дүнг харгалзан Давж заалдах комиссын бүрэлдэхүүн хэн нь ямар хэмжээгээр хариуцахыг эцэслэн тогтооно.



## Комиссын шийдвэр гаргах, хүчин төгөлдөр болох

**Олонхын зарчим:** 3 бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа олонхын саналаар буюу 2-оос доошгүй саналаар шийдвэрийг батална. Санал тэнцэх эрх зүйн зохицуулалт байхгүй (Бүрэлдэхүүний даргалагч шийдвэрлэх саналтай байна)

**Шийдвэрийн хэлбэр:** Шийдвэр нь заавал бичгээр гарч, үндэслэл бүхий дүгнэлтүүдийг тодорхойлсон байх бөгөөд Давж заалдах комиссын бүрэлдэхүүн бүрэн бүрэлдэхүүнээрээ гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**Эцсийн шийдвэр:** Давж заалдах комиссын гаргасан шийдвэр нь Монгол Улсын хэмжээнд спортын салбарт эцсийн шийдвэр байх бөгөөд талууд үг дуугүй биелүүлэх үүрэгтэй. (Олон улсын хэмжээний тамирчин бол Спортын арбитрын шүүхэд буюу CAS-д давж заалдах эрхтэй).



## АРБИТРЧДАД ӨГӨХ ПРАКТИК ЗӨВЛӨМЖ БУЮУ АРБИТРЧ НАРЫН 6 АЛТАН ДҮРЭМ

### 1. "Процессын алдаа" бол хамгийн том эрсдэл мөн

Допингийн маргаан Олон улсын спортын арбитрын шүүх (CAS)-д очоод хүчингүй болох хамгийн түгээмэл шалтгаан нь шийдвэрийн агуулгаас илүү процессын (горимын) алдаа байдаг.

Зөвлөмж: Тамирчны тайлбар өгөх, нотлох баримт гаргаж өгөх хугацааг дүрмийн дагуу бүрэн хангасан эсэхийг алхам тутамд хяна.

Алтан дүрэм: Хуралдааны товыг дүрмээр тогтоосон хугацаанд багтааж, мэдэгдэх хуудсыг талуудад гардуулсан уу гэдэг нь шийдвэр хууль ёсны байхын суурь үндэс юм.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



## 2. WADA Кодекс ба Дотоодын дүрмийн уялдааг хангах

Допингийн маргаан бол зөвхөн Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль эсвэл Иргэний хуулиар зохицуулагддаг ердийн маргаан биш юм. Энэ нь Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA)-ын олон улсын стандартаар удирдагддаг.

Зөвлөмж: Давж заалдах комиссын бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа Монгол Улсын Спортын арбитрын дүрмээс гадна тухайн жилийн WADA-ийн "Хориглосон жагсаалт", "Шинжилгээ ба мөрдөн шалгах олон улсын стандарт"-ыг заавал давхар эш татаж, шийдвэрийнхээ үндэслэл болгох шаардлагатай.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



### 3. Бодит хараат бус байдлыг баримтлах (Impartiality & Independence)

Спортын ертөнц жижиг учраас арбитрч нар тамирчин, дасгалжуулагч эсвэл тухайн спортын холбооны удирдлагуудтай ямар нэг байдлаар танил, найз нөхөд эсвэл нэг клубт харьяалагддаг байх тохиолдол элбэг байдаг.

**Зөвлөмж:** "Би уул нь шударга шийдэж чадна" гэж дотооддоо бодох нь хангалтгүй. Талуудын нүдэнд та ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй харагдаж л байвал шууд татгалзан гарах (Recusal) эсвэл үүнийгээ талуудад ил тод мэдэгдэх (Disclosure) хэрэгтэй. Шударга байх нь өөрөө ил тод харагдаж байх ёстой.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



**4. Нотлох баримтыг үнэлэхдээ "Strict Liability" зарчмыг мартаж болохгүй**  
Допингийн хэрэгт "Үл маргах хариуцлагын зарчим" (Strict Liability) үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, тамирчны бие махбодоос хориглосон бодис илэрсэн л бол түүнийг "санаатай уугаагүй", "хүн миний уух юманд хийчихсэн байсан", "эмч андуураад тарьчихсан" гэх мэдүүлэг нь зөрчил гаргаагүй гэж үзэх үндэслэл болохгүй.

Зөвлөмж: Эдгээр тайлбар нь зөвхөн эрх хасах хугацааг хөнгөрүүлэх, багасгах үндэслэл болохоос биш, тамирчныг допингийн зөрчил гаргаагүй гэж цагаатгах үндэслэл болохгүй гэдгийг шинэ арбитрч нар маш сайн ухамсарлах хэрэгтэй.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



## 5. Нууцлалыг чанд хадгалах үүрэг

Допингийн маргаан нь тамирчны спортын карьер төдийгүй хувь хүний нэр хүнд, сэтгэл зүйд асар том цохилт болдог.

Зөвлөмж: Арбитрын шийдвэр албан ёсоор гарч, нийтэд зарлах хүртэл хэргийн материал, хуралдааны явц, арбитрчдын дунд өрнөсөн саналын зөрүү зэргийг гэр бүл, хамт олон болон хэвлэл мэдээллийнхэнд ямар ч хэлбэрээр (сошиал медиа, ам яриа) задруулж болохгүй.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



## 6. Бичгээр гарах шийдвэрийн чанар

Шийдвэрийн "Тогтоох хэсэг" нь маш тодорхой, ямар нэгэн хоёр утгагүй байх ёстой.

Зөвлөмж: Эрх хасах хугацааг тогтоохдоо "Хэзээнээс эхэлж, хэзээ дуусах" огноог нарийвчлан зааж өгөх хэрэгтэй. Мөн уг хугацаанд тамирчны урьд нь гаргасан амжилтыг хүчингүй болгох эсэх, авсан медаль, шагналыг хураах эсэхийг шийдвэрт заавал нэг бүрчлэн тусгана.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА